

Монголын хүн амын нас, хүйсийн бүтцэд гарч буй өөрчлөлтүүд, түүний үр нөлөө

Б. Мөнхжаргал

МУИС, ХАЗССТ-ийн магистрант

Хүн амын бүтэц, шинж байдлын талаарх судалгаа нь хүн ам зүйн судалгааны чухал хэсэг байдаг бөгөөд тэдгээрээс нас, хүйсийн бүтцийн судалгаа нь тухайн орны хүн амын нөхөн үржихүйн цаашдын чиг хандлагыг тодорхойлоход төдийгүй нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөвлөлтөд, тухайлбал нийгэм хангамж, боловсрол, эрүүл мэндийн салбарт оруулах хөрөнгө оруулалтын бодлого боловсруулахад, мөн улс орны нийгэм, эдийн засгийн амьдралд өдөр тутам оролцож байдаг жирийн хүмүүст ч, ихээхэн ач холбогдолтой. Тухайлбал, бизнесмен хүн тухайн зах зээл дээрх хэрэглэгчдийн шинж байдал, бүтэц, онцлогийг судалж мэдэхгүйгээр, тэднийг өөртөө татаж үйл ажиллагаагаа амжилттай хөтлөх аргагүй юм.

Монголын хүн амын нас, хүйсийн бүтцийн өнгөрсөн ба өнөө үеийн байдал

Монгол улс ХХ зуунд нийгэм, эдийн засгийн хөгжлийн хэд хэдэн үеийг туулж ирсэн бөгөөд хүн ам зүйн хөгжил, хүн амын насны бүтцийн бүрэлдэн тогтсон байдлаар нь дараах үеүдэд хуваан судалж болно. Үүнд:

1. 1956 оноос өмнөх үе: Хүн амын нөхөн үйлдвэрлэл удаан; нас, хүйсийн бүтэц дэвшилтэт бус хэлбэртэй үе
2. 1956-1990 он хүртэлх үе: Хүн амын нөхөн үйлдвэрлэл хэт хурдан, насны бүтэц залуужсан үе
3. 1990-2000 оны үе: Хүн амын нөхөн үйлдвэрлэл хурдан, насны бүтэц залуугаас идэрших хандлагад орж буй үе.

1990 оноос өмнөх Монгол улсын хүн амын нас, хүйсийн бүтэц, түүний хүн амын өсөлт, өөрчлөлт болон нийгэм-эдийн засгийн хөгжилд үзүүлсэн үр нөлөө.

1956 оноос өмнөх үе: Монгол улс ХХ зууны эхэнд 1918, 1924, 1935, 1944 онуудад хүн амын тооллого явуулсан гэж түүхэн баримт бичгүүд болон статистикийн мэдээнүүд дээр дурьдсан байдаг боловч тэдгээр нь насны бүтцийн хувьд сүүлийн үеийн мэдээ баримтуудтай харьцуулагдахуйц байж чадахгүй байгаа тул 1956 оны хүн амын тооллогоос өмнөх үеийн хүн амын насны бүтцийг төдийлөн нарийвчлан тодорхойлох боломжгүй юм. Гэхдээ байгаа мэдээллүүдээс харахад, манай улсын хүн ам ХХ зууны эхний 50 жилд маш бага өсөлттэй, хүн амын насны бүтэц өмнөх үеийн урт удаан хугацаанд үргэлжилсэн хүн ам зүй ба нийгэм, эдийн засгийн таагүй нөхцлүүдээс үүдэн зохисгүй байдалтай байсан бөгөөд зарим эрдэмтэд

тухайн үед Монголчуудыг "мөхөж буй үндэстэн" гэж тодорхойлж байжээ. Энэ үеийн хүн амын насны бүтцийн ерөнхий байдлыг Хүснэгт 1-ээс харж болно:

Хүснэгт 1. Монгол улсын хүн ам насны бүтцээр, 1930-1950 онд

Он	Нийт хүн ам /мянган хүн/	Үүнээс (дүнд эзлэх хувиар)		
		16 хүртэл насны	16-45 насны	46-аас дээш насны
1930	727.4	28.1	46.6	25.3
1940	738.6	30.6	46.5	22.9
1950	758.9	30.6	44.5	24.9

Мэдээллийн эх үүсвэр: Т. Навч. "Монголын хүн амын динамик эгнээ",

1950 он хүртэл манай улсын хүн амын насны бүтцэд онцын өөрчлөлт гараагүй бөгөөд залуу хүн амын эзлэх хувийн жин бага, хөгшин хүн амын эзлэх хувь нэлээд их байсан нь Хүснэгт 1.1-ээс харагдаж байна. Ийнхүү хүн амын насны бүтэц төдийлөн өөрчлөгдөөгүй байгаа нь хүн амын өсөлтөд гол нөлөөлөгч үзүүлэлт болох төрөлт, нас баралтын түвшин тухайн үед мэдэгдэхүйцээр өөрчлөгдөж чадаагүйг харуулж байна. 1921 онд Ардын хувьсгал ялснаас хойш улс орон хөгжих чухал үүд хаалга нээгдсэн боловч Дэлхийн II дайн, Халх голын дайн, Үндэстний сэхээтнүүдийг хамарсан Их хэлмэгдүүлэл зэргээс гадна 1940-өөд оныг хүртэл эрэгтэй хүн амын нэлээд хэсэг нь лам байснаас гэр бүл болоогүй эмэгтэйчүүдийн хувийн жин ихээр нэмэгдэж, элэг бүтэн, олон хүүхэдтэй айл өрх цөөхөн болж өрхийн бүтэц гажуудалд орсон, мөн хүн амын эрүүл мэндийн асуудал туйлын хүнд байсан зэргээс үүдэн насны бүтцэд онцын өөрчлөлт гарч чадаагүй юм.

1956-1990-ээд оны үе: Дэлхийн II дайнаас хойш улс орон тайван замаар хөгжих боломж бүрдэн, нийгмийн бүтээн байгуулалтад ажиллах хүчний ихээхэн хэрэгцээ бий болсон нь төрөөс хүн амын өсөлтийг дэмжих идэвхтэй бодлогуудыг баримтлахад хүргэснээс гадна 1950-иад оны дунд үеэс Зөвлөлтийн эмч, мэргэжилтнүүдийн тусламжтайгаар хүн амыг бүхэлд нь эрүүлжүүлэх талаар үнэлж баршгүй чухал арга хэмжээнүүдийг авч явуулсан нь манай улсын хүн ам цаашид өсч, насны бүтэц дэвшилтэт хэлбэртэй болох үндэс нь болж өгчээ. Ийнхүү 1950-иад оны дунд үеэс эрчимтэй нэмэгдсэн төрөлт нь цаашдын хүн амын залуужилтыг тодорхойлох гол хүчин зүйл болж, хүн амын өсөлт, насны бүтцэд нааштай өөрчлөлтүүд гарч эхэлснээр барахгүй хүн ам ихээхэн залуужсан нь Хүснэгт 2-оос харагдаж байна:

Хүснэгт 2. Монгол улсын хүн ам насны бүтцээр, 1950-1989 онд

Он	Нийт хүн ам /Мянган хүн/	Үүнээс:		
		0-15 насны	16-59 насны	60-аас дээш насны
1950	758.9	30.6	59.4	9.9
1956	845.5	32.2	57.7	10.1
1963	1017.2	40.4	49.7	9.8
1969	1197.6	46.1	44.8	9.1
1979	1595.0	46.8	45.9	7.3
1989	2044.0	44.2	49.9	5.8


Мэдээллийн эх үүсвэр: "Монгол улсын хүн ам", УБ., 1994 он.

Нөхөн үржихүйн цаашдын хандлага, өсөлтөд чухал үүрэг гүйцэтгэх залуу хүн амын нийт дүнд эзлэх хувь 1950 онд 30.6 байсан бол түүнээс хойш тоо болон чанарын хувьд маш эрчимтэй нэмэгдэж, 1979 он гэхэд 46.8 хувь болсон нь хамгийн оргил хэмжээнд хүрсэн үе байжээ. Үүнийг дагалдан хөдөлмөрийн насны хүн амын нийт дүнд эзлэх хувь тус онуудад 59.4-өөс 45.9, хөгшин насны хүн амын хувь 9.9-өөс 7.3 болон буурсан байна. Ийнхүү хүн амын насны бүтэц ихээхэн залуужсаны гол шалтгаан нь төрөлтийн түвшний огцом өсөлт /1960-1980-аад оныг манай улсын түүхэнд "хүн амын өсөлтийн тэсрэлт" болсон үе гэдэг/ юм.

1970-аад оны дундаас хойш хүн амын төрөлт абсолют хэмжээгээрээ нэмэгдсээр байсан ч чанарын хувьд буурч эхэлсэн. Өөрөөр хэлбэл, төрөөс төрөлтийг дэмжих хатуу бодлого баримталж байсан боловч аливаа нийгмийн хөгжлийн ерөнхий зүй тогтлыг даган хүн амын төрөлтийн түвшин буурч эхэлснээр хурдацтай нэмэгдэж байсан 0-15 насны хүн амын нийт дүнд эзлэх хувь 1969-1989 онд 46.1-ээс 44.2 болон буурснаас гадна хөдөлмөрийн насныхны хувь 44.8-аас 49.9 болон нэмэгдэж, тэтгэврийн насныхны хувь 9.1-ээс 5.8 болон буурчээ. Үүний дүнд хүүхэд ба хөгшин насны хүн ам зүйн ачааллууд зэрэг буурч эхэлсэн юм. 1990 оноос өмнө Монгол улсын хөдөлмөрийн насны хүн амд ногдох хүн ам зүйн ачаалал ямар байдалтай байсныг Зураг1-ээс харж болно.

Хүн ам зүйн ерөнхий ачаалал 1950-иас 1990 он хүртэлх хугацаанд өөрчлөгдөхдөө 1969 онд хамгийн оргил үедээ хүрч, хөдөлмөрийн насны 100 хүн тутам ойролцоогоор 123.5 хөдөлмөрийн бус насны хүнийг тэжээхээр болсон бөгөөд энэ хугацаанд хүүхэд насны хүн амын ачаалал жилд дунджаар 2.7 пунктээр нэмэгдсэн байхад хөгшин насны хүн амын ачаалал 0.2 пунктээр нэмэгдэж байжээ. Харин 1969 оноос хойш дээр өгүүлснээр хүн ам зүйн ерөнхий ачаалал буурч эхэлснийг хүүхэд насны болон хөгшин насны хүн амын ачааллууд зэрэг буурч эхэлсэнтэй холбон тайлбарлаж болох боловч цаад гол шалтгаан нь төрөлтийн түвшний бууралт, өмнөх өндөр төрөлттэй үеийн хүүхдүүд хөдөлмөрийн насанд шилжин орох

болсонтой холбоотой. Ийнхүү хөдөлмөрийн насны хүн амд ногдох хүүхдийн ачаалал нэлээд нэмэгдэж эхэлсэн ч төрөөс хүн амын өсөлт, төрөлтийг дэмжих шууд болон шууд бус олон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхдээ эх, хүүхдийн эрүүл мэнд, нийгмийн халамжийн асуудалд гойд анхаарал тавьж байсан нь /тухайлбал, эхийн амрах байр ажилладаг байсан, хүүхдүүдийг цэцэрлэг, яслид үнэ төлбөргүй асардаг байсан гэх мэт,/ хүн амын ачааллыг үүрэх хүмүүст сэтгэл зүйн ихээхэн бэлтгэл, дэмжлэг болж чадсан гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл, манай орны хүн амын өсөлтийн тэсрэлт, насны бүтцийн залуужилт нь социалист системээр хөгжлийг удирдаж байсан үед болсон учраас нийгэмд ядуурал, өлсгөлөн, гуйланчлал, ажилгүйдэл зэрэг илт сөрөг үзэгдлүүдийг бий болгоогүй гэж үзэж болох юм.




Он	1956	1963	1969	1979	1989
Голч нас	26,6	22,8	18,6	17,5	18,7

Мэдээллийн эх үүсвэр: "Монгол улсын хүн ам" УБ., 1994 он.

1956 онд манай улсын хүн амын тал хувь нь 26.6-аас доош, нөгөө тал хувь нь түүнээс дээш настай байсан ба 1979 он хүртэл уг голч нас тасралтгүй буурсаар 17.5 болжээ. Харин энэ үеэс хойш төрөлтийн түвшний бууралт, хөдөлмөрийн насны хүн амын өсөлттэй холбоотойгоор голч нас нэмэгдэж 1989 он гэхэд 18.7 болжээ. Гэсэн хэдий ч 1989 оны байдлаар манай улс дэлхийд залуу хүн амтай орны тоонд багтсан хэвээр байжээ.

Ингээд 1990 оноос өмнөх Монгол улсын хүн амын нас, хүйсийн бүтцийг хүн амын нас, хүйсийн суваргыг ашиглан нэгтгэн харуулъя: (Зураг2)

Зураг 2. Монгол улсын хүн амын нас, хүйсийн суварга, 1956 ба 1979 онд



Мэдээллийн эх үүсвэр: Монгол улсын хүн ам. УБ., 1994 он

Зураг 2-оос хүн амын нас, хүйсийн бүтцийг зэрэг харж болох бөгөөд 1956 оны суварга нь тухайн үеийн хүн амын төрөлтийн түвшин бага, хүн амын ихэнхийг 15-59 насныхан эзэлж байсныг харуулж байна. Мөн уг оны суваргад 10-14 насны хүн амын нийт дүнд эзлэх хувь эрс бага байгаа нь өмнөх жилүүдийн нийгэм, улс төрийн таагүй байдлаас /хэлмэгдүүлэл, эх орны дайн гэх мэтийн хар сүүдэр бүрэн арилаагүй байсан/ хүн амын төрөлтийн түвшин хэтэрхий бага байсан болон дэлхийн II дайнд олон хүмүүс амь үрэгдсэний нөлөө юм. Хүйсийн бүтцийн хувьд залуу болон идэр насанд хүн амын хүйсийн харьцаа бараг тэнцвэртэй, хөгшин насанд эрэгтэй нь бага болсон байгаа нь амьдралын туршид эрэгтэйчүүдийн нас барах магадлал эмэгтэйчүүдийнхээс өндөр, өөрөөр хэлбэл дундаж наслалт нь бага байдгийг баталж байна.

1979 оны хүн амын нас, хүйсийн суваргыг харвал, харьцангуй зөв хэлбэртэй болсон байгаа бөгөөд хүн амын дунд 0-19 насны хүүхэд, өсвөр үеийнхэн ихэнх хувийг эзлэх болжээ. Өөрөөр хэлбэл, уг суваргын суурь хэсгээс 1960-аас 1980-аад оны хүн амын өндөр төрөлтийн түвшинг харж болно. Энэхүү хүн амын залуу бүтэц нь тухайн үедээ хүн ам зүйн ачааллыг нэмэгдүүлж, улс орны нийгэм, эдийн засгийн зүгээс тэдэнд тавих халамж анхаарлыг /ялангуяа нялхас, хүүхдийн эрүүл мэндэд чиглэсэн халамж, дундаас доош түвшингийн боловсролын хэрэгцээг хангах гэх мэтэд чиглэсэн асуудлууд дээр/ нэмэгдүүлэхийг шаардаж байсан талтай ч цаашдын хүн амын, өсөлт нөхөн үржихүйд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Өөрөөр хэлбэл, энэхүү суваргыг хараад тухайн хүн ам цаашид залуужих хандлагатай байна гэж дүгнэж болно.


1990-2000 оны Монгол улсын хүн амын нас, хүйсийн бүтэц

1989 онд Монгол оронд ардчиллын хөдөлгөөн идэвхтэй өрнөж, улс орон зах зээлийн эдийн засгийн системээр хөгжих замыг сонгон авсанаар нийгмийн амьдралд маш их өөрчлөлт гарч хүний эрх, эрх чөлөө, эрх тэгш байдал, хүний сонголт, хүний хөгжил, хүний нөөц, хотжилт, гадаад шилжих хөдөлгөөний идэвхжил гэх мэт хүн амын бүх асуудлууд улс, олон түмний анхаарлыг улам хурцаар хөндөх болсноос гадна хүн амын бодлогын асуудалд нэлээд өөрчлөлт орж ХХ зуунаас хойш хүн амын талаар баримталж ирсэн бодлогын хөгжлийн 2 дахь үе шат эхэлсэн гэж болно. Хэдийгээр хүн амаа өсгөх бодлого баримталж байгаа нь өмнөхтэй адил ч гэсэн түүнийгээ хэрэгжүүлэх арга зам нь маш их ялгаатай болсон. Тухайлбал, урьд нь төрөлтийг шууд дэмжиж байсан бол одоо төрөлтийг эх, хүүхдийн эрүүл мэндэд тохиромжтойгоор зохицуулах таатай нөхцөл бүрдүүлэх, эх, нялхсын эндэгдлийг тууштай бууруулах замаар хүн амын өсөлтийг хангах бодлого барьж байгаа юм. Манай оронд тогтвортой хөгжил, хүн амын зохистой өсөлт, гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэнд гэх мэт сүүлийн үед ихээр яригдаж хэрэглэгдэх болсон ойлголт, арга хэмжээнүүд нь бүгд дээрх бодлогыг хэрэгжүүлэхэд тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа нь ойлгомжтой. Эдгээрийн ихэнх нь хүн амын төрөлт огцом буурахад шууд нөлөөлж байгааг шүүмжилж болох талтай ч нөгөө талаас энэхүү төрөлтийг зохицуулах хандлага нь өнөөдөр зөвхөн манай оронд төдийгүй дэлхийн ихэнх улс оронд ажиглагдаж, тохиолдоод байгаа үзэгдэл бөгөөд хүний эрхийн асуудал заавал хөндөгдөх юм. Ийнхүү хүн ам зүйн шилжилтийн онолын дагуу манай орны хүн амын төрөлтийн түвшин аль хэдийн буурч эхэлсэн байгаа ч түүнийг улам хурдацтай буурахад нөлөөлж буй дээрх хүчин зүйлүүдийн нөлөөгөөр, мөн наслалт болон, нялхсын эндэгдэлд төдийлөн нааштай үр дүн гарч чадахгүй байгаагаас үүдэн 1990 оноос хойш хүн амын насны бүтцэд нэлээд өөрчлөлт гарлаа.

Нас, хүйсийн бүтцэд гарч буй өөрчлөлтүүд, түүний хүн амын өсөлт, өөрчлөлт болон нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлж буй нөлөө

Нийгмийн хөгжлийн зүй тогтлоор манай улсын хүн амын төрөлтийн түвшин буурч эхлээд байсан ч гэсэн энэхүү авч үзэж буй хугацааны эхэнд нийгэм, эдийн засгийг удирдах хуучин тогтолцоо өөрчлөгдсөнөөр өмнөх социализмын гэгдэх үед далд байсан ажилгүйдэл, ядуурал гэх мэт нийгэм, эдийн засгийн сөрөг үзэгдлүүд ил тод болж, үүнтэй холбоотойгоор гэр бүлийн бүтэц нэлээд өөрчлөгдөн, өнөр гэр бүлээс цөөн гишүүдтэй гэр бүл зонхилох болжээ. Мөн залуу хүмүүсийн гэрлэх нас хожуусаж, цөөн хүүхдийг эрмэлзэх хандлага бий болсон, гэр бүл төлөвлөлтийн хөтөлбөрүүд хэрэгжих болсон зэрэг нийгмийн гэж болох нөхцөл байдлуудаас гадна үр хөндөлтийг чөлөөтэй болгосон явдал нь 1990-ээд

оноос хүн амын төрөлтийн түвшинг улам хурдацтай бууруулж эхэлсэн юм. Түүний нөлөөгөөр нийт хүн амын дунд залуу хүн амын эзлэх хувь багасч, хөдөлмөрийн насны хүн амын хувь нэлээд нэмэгдсэн нь Зураг3-аас харагдаж байна.



Он	1989	2000
Голч нас	18,7	21,6

Мэдээллийн эх үүсвэр: Монгол улсын хүн ам. УБ., 1994 он; 2000 оны хүн ам, орон сууцны тооллогын урьдчилсан мэдээ

1989-2000 он гэхэд нийт хүн амын дунд залуу хүн амын эзлэх хувь 41.8-35.8 болон огцом буурч, өмнөх төрөлт өндөр үеийн хүүхдүүд хөдөлмөрийн насанд орцгоож байгаатай холбоотойгоор хөдөлмөрийн насны хүн амын нийт дунд эзлэх хувь 52.4-өөс 58.9 хувь болж нэмэгджээ. Харин хөгшин хүн амын нийт дунд эзлэх хувь бага зэрэг буурч 5.8-5.3 болсон байна.

1989 оны байдлаар хүн амын тал хувь нь 19-өөс доош насныхан байсан бол уг голч нас 10 жилийн хугацаанд 3 орчим насаар нэмэгдэж 21.6 болжээ.

Энэхүү хугацааны хүн амын нас, хүйсийн ерөнхий бүтцийг суврагаас харвал (Зураг4), дараах онцлогууд харагдаж байна. Үүнд:

- 1989-2000 онд хүн амын насны бүтэц ерөнхийдөө залуу хэвээр байгаа боловч 2000 онд суваргын суурь эрс хумигдаж, хүн амын залуужилтыг 10-34 насныхан, ялангуяа 10-24 насны өсвөр үеийнхэн ба шинээр хөдөлмөрийн эгнээнд орох насныхан тодорхойлох хандлагатай болсон байна.
- Хүйсийн бүтэц харьцангуй тогтвортой, түүнийг огцом өөрчлөх хүн ам зүйн бус ямар нэгэн үйл явдал болоогүй байгаа бөгөөд хүүхэд насанд эрэгтэйчүүд бага зэрэг илүү, хөгшин насанд эмэгтэйчүүд илүү байдал



ажиглагдаж байна.

- 2000 оны суваргаас хүн амын насны бүтэц идэрших хандлага руу ойртож байгааг харж болно.

Зураг 4. Монгол улсын хүн амын нас, хүйсийн суварга, 1989 ба 2000 онд

Монгол улсын хүн амын нас,
хүйсийн суварга, 1989 онд

Монгол улсын хүн амын нас,
хүйсийн суварга, 2000 онд



Мэдээллийн эх үүсвэр: Монгол улсын хүн ам. УБ., 1994 он; 2000 оны хүн ам, орон сууцны тооллогын урьдчилсан мэдээ

Ийнхүү манай орны хүн амын дунд хөдөлмөрийн насныхны эзлэх хувь эрс нэмэгдэж буй нь эдийн засгийн шилжилтийн үетэй давхцаж буй онцлогтой бөгөөд үүнтэй холбоотойгоор ч гэж болох нийгэм, эдийн засгийн олон бэрхшээлтэй асуудлууд үүсээд байна. Тухайлбал, бага, дунд сургуулийн боловсролын эрэлт хэрэгцээнээс илүү дээд боловсрол, ажлын байрны хэрэгцээ зэрэг нь анхаарал татсан асуудал болж байгаа бөгөөд манай оронд сүүлийн жилүүдэд бүртгэлтэй ажилгүйчүүд буурч байгаа үзүүлэлттэй боловч түүний цаана бүртгэлгүй ажилгүйчүүд маш олон байгаа юм. Жишээ нь, 1998 оны байдлаар 49837 бүртгэлтэй ажилгүйчүүд, 221410 бүртгэлгүй ажилгүйчүүд байна гэж ЭМНХЯ-ны Мэдээлэл, хяналт, шинжилгээ, үнэлгээний газараас гаргасан "Эрүүл мэнд, хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сүүлийн 5 жилийн зарим үзүүлэлтүүд" мэдээнд дурджээ. Мөн 1997 онд бүртгэлтэй-63690, бүртгэлгүй-78858 ажилгүйчүүд байхад, шинээр бий болгосон болон чөлөөлөгдсөн ажлын байр нь /орон тоо нь/ 19487 (ҮСГ-ын мэдээ) байна.

Энэ бүхнээс харахад, хүн амын насны бүтэц нь одоогоор нийгэм, эдийн засагт нэлээд бэрхшээлүүдийг үүсгээд байгаа ч гэсэн эдийн засгийн сэргэлт, өсөлт мэдэгдэхүйц хэмжээнд хүрч, хөдөлмөрийн нөөцийг хангалттай хэмжээнд ашиглаж чадвал хүн амын насны бүтэц нь хүн ам зүйн ачаалыг бодитоор бууруулах, эрүүл мэндийн зардлыг багасгах / нялхас, хүүхэд нь эрүүл мэндийн зардал их шаарддаг бүлэг юм/ зэргээр эргээд нийгэм, эдийн засагт чухал нөлөөллүүдийг үзүүлэх боломжтой юм. Энэ нь дараах хүснэгтээс харагдаж байна. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Хүн ам зүйн ачаалал, Монгол улс, 1989, 2000 онд

Он	Хүн ам зүйн ачаалал		
	Хүүхдийн	Хөгшин хүн амын	Ерөнхий
1989	76,1	10,7	86,8
2000	60,6	8,9	69,5

Мэдээллийн эх үүсвэр: Монгол улсын хүн ам, УБ., 1994 он; 2000 оны хүн ам, орон сууцны тооллогын урьдчилсан мэдээ.

Хүснэгт 1.3-аас харахад, хөдөлмөрийн насны хүн амд ногдох тэжээлгэгчдийн тоо буюу ачаалал маш их буурч сүүлийн 40-өөд жилд хамгийн доогуур түвшинд хүрээд байна. Тухайлбал, 1989 онд хөдөлмөрийн насны 100 хүн 76 хүүхэд, 11 өндөр настныг тэжээж байсан бол энэ ачаалал нь 2000 онд 60 хүүхэд, 9 өндөр настан болж өөрчлөгджээ.

Дүгнэлт

XX зууны эхэн гэхэд өмнөх үеийн удаан хугацаанд үргэлжилсэн хүн ам зүй ба нийгэм, эдийн засгийн таагүй нөхцлүүдээс үүдэн манай улсын хүн амын дунд залуу хүн амын эзлэх хувь бага, хөгшин хүн амын эзлэх хувь нэлээд их байсан ба энэ нь 1950-иад он хүртэл хадгалагдаж, насны бүтцэд онцын өөрчлөлт гарч чадаагүй юм.

1950-иад оноос хойш нийгэм, эдийн засгийн тогтворжилтыг даган "хүн амын өсөлтийн тэсрэлт" явагдах үндсэн нөхцөл бүрдэж, түүний дүнд хүн амын насны бүтэц ихээхэн залуужсан бөгөөд уг хүн амын залуужилт хоёр мөчлөгийг дамжаад байна гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл, 1956-1980-аад оны хүн амын залуужилтыг бий болгосон гол хүчин зүйл нь төрөлтийн түвшний дээшлэлт байсантай холбоотойгоор хүн амын залуужилтыг тодорхойлогч гол бүлэг нь хүүхдүүд байсан бол, 1979-2000 онд уг бүлэг нь өсвөр үеийнхэн болон хөдөлмөрийн эгнээнд шинээр шилжиж буй насныхан болсон. Энэ залуужилтыг бий болгож буй гол хүчин зүйл нь хүн амын инерцийн өсөлт буюу төрөх болон гэрлэх насны эмэгтэйчүүдийн эгнээ өргөжсөнөөр төрөлт нэмэгдэж байгаа явдал юм. 1956-1979 оны хүн амын насны бүтцийг хараад цаашид хүн ам залуужих хандлагатай байна гэж

дүгнэж болохоор байсан ба үнэхээр одоо ч гэсэн манай орон дэлхийд залуу хүн амтайд орж байна. Харин сүүлийн үед хүн ам, гэр бүл, хосуудын дунд ерөнхийдөө төрөлтөө зохицуулах эрмэлзэл, хандлага нэгэнт бий болсон болохоор одоогийн манай хүн амын насны залуу бүтэц нь хүн амын цаашдын өсөлт, нөхөн үржихүйд чанарын өсөлт гаргана гэж дүгнэхэд хэцүү ч дор хаяж, тооны буюу инерцийн өсөлтийг бий болгох боломжтой юм.

Хүн амын насны бүтцийн дээрх онцлогтой холбоотойгоор хөдөлмөрийн насны хүн амд ногдох хөдөлмөрийн бус насны хүн амын ачаалал, ялангуяа хүүхдийн ачаалал 1990 оноос өмнө ихээхэн нэмэгдсэн боловч энэ нь улс орныг төвлөрсөн төлөвлөгөөгөөр удирддаг, нийгмийн хамгаалал өндөр түвшинд байсан үед (социализмын гэгдэх үед) болсон учраас ядуурал, ажилгүйдэл гэх мэт сөрөг үр дагаврыг бий болгоогүй (далд хэлбэрээр байсан байж болохыг үгүйсгэхгүй). Харин сүүлийн жилүүдэд хүн ам зүйн ачаалал буурч байгаа нь эдийн засаг хурдацтай өсөхөд сайн нөлөөтэй ч, нөгөө талаар дээрх хөдөлмөрийн насны хүн амыг ажлын байраар хангаж чадахгүй, хөдөлмөрлөх чадварыг нь ашиглаж чадахгүй бол хүн ам зүйн ачаалал бодитоор буурч байна гэж хэлэхэд бэрх бөгөөд ядуурал, ажилгүйдэл гэх мэт манай оронд бодитоор гарч ирчихээд байгаа үзэгдлүүдийг улам даамжруулж болох талтай.

(Сэтгүүлийн дараагийн дугаараар хүн амын нас, хүйсийн бүтцийн ирээдүйн хандлага, нөлөөг илүү тодорхой авч үзэх болно.)

Ашигласан материал

1. ҮСГ, "Монгол улсын эдийн засаг, нийгэм". Статистикийн жилийн эмхтгэл. УБ., 1995, 1998, 1999 он.
2. ҮСГ, "Монгол улсын хүн ам 1994". УБ., 1994 он.
3. 2000 оны хүн ам, орон сууцны тооллогын урьдчилсан гүйцэтгэлээрх мэдээ.
4. ЭМНХЯ-Мэдээлэл, хяналт, шинжилгээ, үнэлгээний газар, "Эрүүл мэнд, хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сүүлийн 5 жилийн зарим үзүүлэлтүүд". УБ., 1999 он.
5. Б.Баясгалан, П. Цэцгээ, Р.Ноиперт, Ж.Баянсан, "Хүн ам зүйн гарын авлага". УБ., 1993 он.
6. "МУ-ын төрөөс баримтлах хүн амын бодлого", УБ., 1996 он.
7. Ц.Цэдэв, "Монгол улсын хүн ам, нөхөн үржихүйн асуудлууд", УБ., 1999 он.
8. Х.Цэдэнсодном. Монголын хүн амын байршилт динамик ба газарзүйн орчин. УБ., 1999 он.
9. International institute for population sciences. "Population dynamics II", Bombay., 1994.
10. United Nations. Department of Economic and Social Affairs. "Population growth, Structure and distribution", New York., 1999.